



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

### ШУТИС-ийн “Хүндэт профессор” цол олгох тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.3, Эрдмийн ба хүндэт цол олгох журмын 7.6, 7.7 заалт, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөлийн 2024 оны 04 дугаар сарын 11-ны өдрийн хурлын шийдвэр, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2024 оны 04 дугаар сарын 11-ны өдрийн хуралдааны нээлттэй санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Монголын ард түмний нүүдэлчин амьдрал, Агийн буриад, Цаатан ард түмний нүүдлийн амьдрал, бөө мөргөлийн талаарх антропологийн судалгаануудыг хийж, дэлхий нийтэд таниулан сурталчлах талаар олон арван ном, судалгааны бүтээлүүдийг туурвиж, Монгол улсын их, дээд сургуулиудыг олон улсын хөтөлбөрт хамруулан, оюутнуудад соёлын антропологийн чиглэлийн боловсрол олгож, хүмүүнлэгийн олон тооны хандивыг Монгол улсад оруулсан бодит хувь нэмрийг нь үнэлж Бүгд Найрамдах Итали Улсын иргэн Давид Беллаталла-д ШУТИС-ийн “ХҮНДЭТ ПРОФЕССОР” цол өргөмжилсүгэй.

Зөвлөлийн дарга

Зөвлөлийн нарийн бичгийн дарга



Т.Намнан

Д.Цолмонбаатар

367210001



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

### “ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дүрэм”-ийг шинэчлэн батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 28-р зүйл, “ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.3; 4.4; 4.5 дахь заалтууд, Эрдмийн зөвлөлийн дүрмийн 2.3, 7.3, 7.5 дахь заалтууд, Эрдмийн зөвлөлийн гишүүдийн нээлттэй санал хураалтын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дүрэм”-ийг хавсралтаар шинэчлэн баталж, Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллахыг Эрдмийн зөвлөлийн дарга Т.Намнан-д үүрэг болгосугай.
2. “ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дүрэм”-ийг батлагдсан өдрөөс нь эхлэн мөрдсүгэй.
3. “ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дүрэм”-ийн 7.3 заалтыг БШУЯ-ны “Дэд профессор, профессор цол олгоход баримтлах нийтлэг шаардлага” батлагдан хэрэгжиж эхлэх өдрөөс уг шаардлагын 3.1 заалтын дагуу өөрчлөлт хийж даган мөрдсүгэй.

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Т.НАМНАН

ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Д.ЦОЛМОНБААТАР

367210003



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

### “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 30.1.1-р зүйл, "ШУТИС-ийн дүрэм"-ийн 4.3; 4.14.1 дахь заалтууд, Эрдмийн зөвлөлийн дүрмийн 2.3, 7.3 дахь заалтууд, Эрдмийн зөвлөлийн гишүүдийн нээлттэй санал хураалтын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөний шинэчилсэн хувилбарыг дэмжиж, Эрдмийн зөвлөлийн гишүүдийн саналыг нэмж тусгаж, холбогдох нэгжээр засварыг хийлгэн ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн хуралд танилцуулж, батлуулахыг дэмжсүгэй.

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Т.НАМНАН

ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.ЦОЛМОНБААТАР

367210005



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

### Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх тухай

“ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.3 дугаар заалт, Эрдмийн зөвлөлийн дүрмийн 1.2; 1.3; 3.2.2; 3.2.6-р заалтууд, Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Сургалт, оюутны хөгжлийн дэд зөвлөлийн 2024 оны 4-р сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хавсралтад заасан бакалаврын 115, магистрын 129, докторын 60 мэргэжил/хөтөлбөр/-ийн чиглэлээр сургалт явуулж, БШУЯ-наас баталсан хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан хөтөлбөрүүдийг Хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцүүлэхийг дэмжсүгэй.
2. Дээд боловсролын тухай хуульд нийцүүлэн Хөтөлбөрийн ерөнхий хорооны үйл ажиллагааг зохицуулах журамд өөрчлөлт хийхийг зөвшөөрсүгэй.
3. Сургалтын хөтөлбөрүүдэд стандарт, шаардлагын дагуу тогтмол үнэлгээ шинжилгээ хийн сайжруулж, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хөтөлбөрийн ерөнхий хороо (Н.Эрдэнэхүү), Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжүүдэд тус тус үүрэг болгосугай.

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Т.НАМНАН

ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.ЦОЛМОНБААТАР

367210009



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

### ШУТИС-д Хот байгуулалтын салбар шинээр байгуулах тухай

“ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.3 дахь заалт, Эрдмийн зөвлөлийн дүрмийн 3.2.1, 5.3, 7.3 дахь заалтууд, Мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журмын 5.1 дэх заалт, БАС-ийн Эрдмийн зөвлөлийн санал, Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Сургалт, оюутны хөгжлийн дэд зөвлөлийн шийдвэр, Эрдмийн зөвлөлийн гишүүдийн нээлттэй санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хот байгуулалтын салбарыг ШУТИС-ийн Барилга, Архитектурын Сургуулийн бүтцэд шинээр байгуулсугай.
2. Хот байгуулалтын салбарын бүтэц, орон тоо, харьяалах сургалтын хөтөлбөрүүд, үйл ажиллагааг шинэчлэн зохион байгуулж, холбогдох шийдвэрүүдийг тушаалаар баталгаажуулан хэрэгжүүлж ажиллахыг ШУТИС-ийн захирал /ректор/ Т.Намнан, БАС-ийн захирал Б.Нарантуяа нарт үүрэг болгосугай.

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Т.НАМНАН

ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.ЦОЛМОНБААТАР

367210007